


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ ЭХНИЙ 02 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр 1,190.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 1,117.0 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 73.1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь төлөвлөсөн дүнгээс 724.7 тэрбум төгрөгөөр буурч, сайжирлаа.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/



2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр улсын төсөв 76.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч, орон нутгийн төсөв 126.5 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсөв 19.1 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 3.6 тэрбум төгрөгийн тус тус ашигтай гарсан байна.

2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 23.5 хувь буюу 226.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт зарлага нь 4.9 хувь буюу 58.1 тэрбум төгрөгөөр буурснаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оноос 284.9 тэрбум төгрөгөөр багасч, улмаар ашигтай гарлаа.

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2018 оны эхний 02 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	457.4	1,069.8	571.2	53.4	-498.5
Засгийн газрын бонд	-348.3	-733.3	-725.8	99.0	7.5
Засгийн газрын зээл	102.5	203.2	72.5	35.7	-130.7
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	87.2	0.0	-	-87.2
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	24.8	0.0	-	-24.8
Өмч хувьчлал	0.0	0.0	9.0	-	9.0
НИЙТ ДҮН	211.7	651.6	-73.1	-11.2	-724.7

Эх сурвалж: Сангийн яам

2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 29.4 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 416.9 тэрбум төгрөгийг тус тус төлж, 101.9 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, мөн 9.0 тэрбум төгрөгийн өмч хувьчлалын орлого төвлөрсөн байна. Шинээр Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд гаргаагүй байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 1,190.1 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 23.5 хувь буюу 226.8 тэрбум төгрөгөөр өссөн, мөн орлогын төлөвлөгөө 9.6 хувь буюу 104.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр нь авч үзвэл улсын төсөв 11.0 хувь буюу 82.9 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын төсөв 7.0 хувь буюу 19.6 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн, харин орон нутгийн төсөв 1.4 хувь буюу 6.0 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын төсөв 22.0 хувь буюу 12.4 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн орлого 22.3 хувь буюу 152.0 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлого 14.1 хувь буюу 51.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн, харин нийгмийн даатгалын сангийн орлого 0.9 хувь буюу 2.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар
Хүснэгт 2. /тэрбум төгрөг/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	863.9	965.5	422.8	416.9	282.2	301.8	56.6	44.1
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	24.8	22.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	87.2	108.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	752.0	834.8	422.8	416.9	282.2	301.8	56.6	44.1
Татварын орлого	572.8	682.9	156.4	157.8	180.0	199.6	56.6	44.1
Орлогын албан татвар	164.7	196.7	114.3	118.7	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	180.0	199.6	56.6	44.1
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	16.7	11.9	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	163.4	216.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	114.6	107.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	2.4	1.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	58.2	80.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	69.5	79.3	25.5	27.2	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	179.2	151.9	266.4	259.1	102.2	102.2	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	105.1	112.1	24.2	18.2	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.1	0.1	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	66.4	33.5	1.4	0.0	102.2	102.2	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	7.6	6.3	240.8	240.8	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/




Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 89.0 хувийг татварын орлого, 11.0 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 29.1 хувь буюу 238.7 тэрбум төгрөгөөр өссөн бол, татварын бус орлого 8.3 хувь буюу 12.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Татварын орлого 1,058.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 14.5 хувь буюу 133.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын 29.8 хувийг орлогын албан татвар, 20.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 20.6 хувийг нийгмийн даатгалын орлого, 10.2 хувийг онцгой албан татвар, 7.6 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 1.1 хувийг хөрөнгийн албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 10.1 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /тэрбум төгрөг/



Төлөвлөгөөтэй харьцуулахад тусгай зориулалтын орлого, онцгой албан татвар болон хөрөнгийн албан татвараас бусад бүх төрлийн татварын орлогууд давж биелсэн байна. Тухайлбал: нэгдсэн төсвийн орлогын албан татвар 13.1 хувь /36.4 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 11.5 хувь /22.4 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 32.6 хувь /53.3 тэрбум.төг/, гадаад үйл ажиллагааны татварын орлого 39.0 хувь /22.7 тэрбум.төг/, бусад татвар 12.1 хувь /11.5 тэрбум.төг/-аар тус тус давж биелсэн, харин хөрөнгийн албан татвар 28.6 хувь /4.8 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 39.3 хувь /0.9 тэрбум.төг/, онцгой албан татвар 5.8 хувь /6.7 тэрбум.төг/-иар тус тус дутуу биелжээ.


Давж биелсэн нийт татварын орлогын өсөлтийн 39.8 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 27.2 хувийг орлогын албан татвар, 16.7 хувийг нийгмийн даатгалын орлого, 8.6 хувийг бусад татвар, төлбөр хураамжийн орлого, 17.0 хувийг гадаад үйл ажиллагааны орлого эзэлжээ.

Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад 2018 оны эхний 02 сарын татварын орлого 238.7 тэрбум төгрөг буюу 29.1 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үеэс орлогын албан татвар 63.8 тэрбум (25.4%), гадаад үйл ажиллагааны орлого 27.0 тэрбум (50.0%), нийгмийн даатгалын орлого 35.3 тэрбум (19.3%), хөрөнгийн албан татвар 0.7 тэрбум (6.6%), нэмэгдсэн өртгийн албан татвар 42.3 тэрбум (24.2%), онцгой албан татвар 41.2 тэрбум (61.8%), бусад татвар, төлбөр, хураамж 28.8 тэрбум (37.1%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь татварын орлого өсөхөд нөлөөлсөн байна. Харин тусгай зориулалтын орлого 20.4 хувь буюу 0.4 тэрбум төгрөгөөр буурсан байна. **Татварын орлогын өсөлтийн 26.7 хувийг орлогын албан татвар, 17.3 хувийг онцгой албан татвар, 14.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 12.1 хувийг бусад татвар, төлбөр, хураамж, 11.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого эзэлж байна.**

Татварын бус орлого 131.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 8.3 хувь буюу 12.0 тэрбум төгрөгөөр буурч, мөн төлөвлөгөөтэй харьцуулахад орлого 29.9 тэрбум төгрөг буюу 18.5 хувиар дутуу төвлөрсөн байна.

Татварын бус орлогын төлөвлөгөө дутуу биелэхэд төсөвт байгууллагын өөрийн орлого 6.1 тэрбум, гадаад хандив, тусламжийн орлого 30.9 тэрбум, татварын бус бусад орлого 0.6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ. Харин газрын тосны орлого 1.7 тэрбум, хүүгийн орлого 4.5 тэрбум, торгуулийн орлого 1.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



Татварын бус орлогын 99.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 0.9 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байна. Нийтлэг татварын бус орлогын 25.4 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 30.3 хувийг газрын тосны орлого, 20.5 хувийг навигацийн орлого, 11.7 хувийг хүүгийн орлого, 3.0 хувийг торгуулийн орлого, 8.9 хувийг бусад орлого эзэлж байна.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн дагуу 20 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 7 нь төлөвлөсөн орлогыг биелүүлсэн болон давуулан биелүүлсэн бол үлдсэн 13 нь 1.5-100.0 хувь дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна. Татварын ерөнхий газар 20.4 хувь, Гаалийн ерөнхий газар 8.6 хувиар тус тус давуулан биелүүлжээ.

2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч,
түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Хүснэгт 3.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөн үеийн	2018 оны эхний 02 сарын гүйцэтгэл			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сангийн сайд	632,444.8	833,678.9	800,108.4	33,570.5	96.0
Татварын ерөнхий газар	407,768.0	471,066.7	567,150.7	-96,084.0	120.4
Гаалийн ерөнхий газар	229,060.0	298,360.3	324,120.3	-25,760.0	108.6
Сангийн яам	-5,560.1	-19,125.7	-60,364.8	41,239.1	315.6
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	0.0	77,866.9	-36,077.6	113,944.5	-46.3
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	2,532.8	222.2	2,310.6	8.8
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,176.9	2,977.9	5,057.5	-2,079.6	169.8
Монгол Улсын Их Хурлын дарга	530.3	4,000.0	122.7	3,877.3	3.1
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	530.3	4,000.0	122.7	3,877.3	3.1
Монгол Улсын Ерөнхий аудитор	0.0	437.8	431.5	6.4	98.5
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	437.8	431.5	6.4	98.5
Монгол Улсын Ерөнхий сайд	1,008.6	2,910.1	4,541.1	-1,631.0	156.0
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	0.0	0.0	0.0	0.0	0.0
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	502.3	0.0	42.6	-42.6	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	506.3	2,910.1	4,498.5	-1,588.4	154.6
Монгол Улсын Шадар сайд	755.0	7,569.7	13,137.6	-5,567.9	173.6
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	470.4	414.7	290.0	124.7	69.9
Стандарт, хэмжил зүйн газар	0.0	316.1	150.8	165.3	47.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	6,598.0	1,002.5	5,595.5	15.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	284.6	240.9	11,694.3	-11,453.4	-
Хууль зүй, дотоод хэргийн сайд	4,860.8	21,180.0	25,857.1	-4,677.1	0.1
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	2,502.5	3,240.0	2,440.7	799.3	75.3
Цагдаагийн ерөнхий газар	0.0	581.3	130.1	451.2	22.4
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	186.1	4,715.4	4,715.6	-0.2	100.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,172.3	12,643.3	18,570.7	-5,927.4	146.9
Гадаад харилцааны сайд	3,177.7	4,819.7	174.8	4,644.8	3.6
Дипломат төлөөлөгчийн газрууд	3,159.3	3,528.0	12.3	3,515.7	0.3
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	18.4	1,291.7	162.6	1,129.1	12.6
Зам, тээврийн хөгжлийн сайд	11,852.6	31,448.8	33,781.5	-2,332.7	0.1
Иргэний нисэхийн ерөнхий газар	10,392.9	26,672.8	26,733.7	-60.9	0.1
Зам, тээврийн хөгжлийн яам	0.0	32.0	32.0	0.0	99.9
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	609.1	2,952.3	1,540.9	1,411.4	52.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	850.7	1,791.6	5,474.9	-3,683.3	305.6
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	42,660.7	45,546.6	47,070.0	-1,523.4	103.3
Ашигт малтмал, газрын тосны газар	41,522.0	42,643.7	45,973.7	-3,330.0	107.8
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0			0.0	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,138.7	2,902.9	1,096.3	1,806.6	37.8
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	18,819.7	40,629.3	9,747.1	30,882.2	24.0
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.0	84.3	0.0	84.3	0.0
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	80.1	525.9	525.9	0.0	100.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	16,548.5	0.0	16,548.5	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	18,739.6	23,470.6	9,221.2	14,249.4	39.3
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	56,804.8	33,144.0	24,896.8	8,247.2	75.1
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	19,895.0	4,000.0	0.0	4,000.0	0.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,748.4	2,644.2	0.0	2,644.2	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	35,161.4	26,499.8	24,896.8	1,603.0	94.0
Эрүүл мэндийн сайд	28,890.9	193,678.3	170,129.8	23,548.5	87.8
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	25,074.1	168,193.6	151,117.9	17,075.8	89.8
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	7.8	1,185.8	0.0	1,185.8	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,808.9	24,298.9	19,011.9	5,287.0	78.2
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	3,585.8	15,509.0	2,125.5	13,383.5	13.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	3,564.1	15,410.7	1,952.5	13,458.2	12.7
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	21.7	98.3	173.1	-74.7	176.0
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	7.0	1,032.2	172.2	860.1	16.7

Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	913.5	0.0	913.5	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	7.0	118.8	172.2	-53.4	145.0
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	1,492.2	104,262.8	2,176.5	102,086.2	2.1
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	101,837.7	430.7	101,407.0	0.4
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,492.2	2,425.0	1,745.8	679.3	72.0
Барилга, хот байгуулалтын сайд	74.7	1,994.3	0.0	1,994.3	0.0
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	0.0	278.3	0.0	278.3	0.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	74.7	1,716.0	0.0	1,716.0	0.0
Батлан хамгаалахын сайд	1,795.0	34,857.8	30,263.3	4,594.5	86.8
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	669.3	5,488.9	5,488.9	0.0	100.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,125.7	29,368.9	24,774.4	4,594.5	84.4
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	2.0	50.0	144.1	-94.1	288.3
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2.0	50.0	144.1	-94.1	288.3
Санхүүгийн зохицуулах хороо	123.5	50.0	50.0	0.0	0.1
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	123.5	50.0	50.0	0.0	100.0
Үндэсний статистикийн хорооны дарга	0.3	121.9	0.3	121.7	0.2
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	121.9	0.0	121.9	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	0.3	0.0	0.3	-0.3	0.0

Эх сурвалж: Сангийн яам

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 1,737.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 64.3 хувийг ашиглаж 620.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 58.1 тэрбум төгрөг буюу 4.9 хувиар буурч, 1,117.0 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/
Хүснэгт 4. /тэрбум төгрөг/

	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,367.7	910.9	451.7	290.4	288.5	282.7	57.2	40.5
НИЙТ ЗАРЛАГА	1,305.9	905.7	444.5	289.4	288.5	282.7	57.2	40.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,086.9	801.7	362.3	281.2	288.5	282.7	57.2	40.5
Бараа, ажил үйлчилгээний зардал	375.1	251.5	262.3	208.5	3.3	2.8	1.0	0.3
Зээлийн үйлчилгээний төлбөр	214.7	107.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Татаас	139.7	128.5	19.6	12.8	0.0	0.0	20.4	7.9
Урсгал шилжүүлэг	357.4	314.1	80.4	59.9	285.1	279.9	35.8	32.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	219.0	104.0	82.2	8.2	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	61.8	5.2	7.2	0.9	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-615.8	-76.1	-28.8	126.5	-6.3	19.1	-0.7	3.6

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад улсын төсвийн зарлага 456.8 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 161.3 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 5.8 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сан 16.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна. Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зардал 64.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зардал 16.8 тэрбум төгрөгөөр тус тус буурч, харин орон нутгийн төсвийн зардал 0.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 4.9 хувь буюу 58.1 тэрбум төгрөгөөр буурахад эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 82.5 хувь буюу 28.9 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 9.3 хувь буюу 11.6 тэрбум төгрөг, урсгал зардал 1.7 хувь буюу 17.6 тэрбум төгрөгөөр тус тус багассан нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зээлийн үйлчилгээний төлбөр 27.5 хувь буюу 40.9 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч, бараа, ажил үйлчилгээний зардал 3.5 хувь буюу 14.8 тэрбум, урсгал шилжүүлэг 2.1 хувь буюу 8.2 тэрбум, татаас 0.4 хувь буюу 0.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. **Онцлоход, зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оноос 40.9 тэрбум, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 107.0 тэрбум төгрөгөөр тус тус бага байгаа нь улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлөв ажиглагдаж байна.**

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл
/Зардлын эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт 5.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2018 оны эхний 02 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,175.1	1,737.7	1,117.0	64.3	620.7
НИЙТ ЗАРЛАГА	1,140.0	1,668.7	1,110.8	66.6	557.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,016.3	1,367.5	998.6	73.0	368.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422.4	612.0	437.3	71.4	174.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278.8	300.7	281.3	93.6	19.4
Үндсэн цалин	240.6	224.3	220.5	98.3	3.8
Нэмэгдэл	24.6	58.2	47.6	81.8	10.6
Унаа хоолны хөнгөлөлт	5.9	7.9	6.5	82.5	1.4
Урамшуулал	1.0	3.9	1.0	24.1	3.0
Гэрээт ажлын хөлс	6.6	6.4	5.8	90.3	0.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23.9	29.7	25.7	86.6	4.0
Тэтгэврийн даатгал	23.8	19.0	16.4	86.6	2.5
Тэтгэмжийн даатгал	0.0	2.4	2.1	86.6	0.3
ҮОМШӨ-ний даатгал	0.0	1.9	1.7	86.6	0.3
Ажилгүйдлийн даатгал	0.0	0.5	0.4	86.6	0.1
Эрүүл мэндийн даатгал	0.0	6.0	5.2	86.6	0.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45.9	59.9	47.5	79.3	12.4
Гэрэл, цахилгаан	7.9	10.4	8.3	80.3	2.0
Түлш, халаалт	31.4	40.7	33.3	81.7	7.5
Цэвэр, бохир ус	3.1	4.9	3.1	63.6	1.8
Байрны түрээс	3.5	4.0	2.9	71.9	1.1
Хангамж, бараа материалын зардал	14.0	24.6	14.6	59.5	10.0
Бичиг хэрэг	1.2	2.0	1.2	59.3	0.8
Тээвэр, шатахуун	5.5	9.2	5.5	59.5	3.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.5	2.5	1.5	58.9	1.0
Ном, хэвлэл	0.1	1.1	0.1	9.4	1.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4.8	7.7	5.2	67.9	2.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.9	2.0	1.1	55.8	0.9
Нормативт зардал	28.5	50.3	26.7	0.0	23.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12.0	24.2	12.0	49.6	12.2
Хоол, хүнс	14.6	19.7	12.3	62.4	7.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.9	6.4	2.4	36.9	4.0
Эд хогшил, урсгал засварын зардал	4.4	9.9	2.9	29.8	6.9
Багаж, техник, хэрэгсэл	2.1	3.6	0.7	20.7	2.8
Тавилга	0.4	0.6	0.2	28.8	0.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.1	0.5	0.1	13.8	0.4
Урсгал засвар	2.0	5.1	1.9	37.9	3.2
Томилолт, зочны зардал	1.9	5.0	2.4	47.9	2.6

Гадаад албан томилолт	0.5	1.7	1.1	62.1	0.7
Дотоод албан томилолт	1.1	2.8	1.1	40.5	1.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	0.2	0.5	0.2	39.0	0.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23.1	97.0	32.7	33.8	64.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19.2	88.3	29.2	33.0	59.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.3	0.8	0.3	35.4	0.5
Даатгалын үйлчилгээ	2.0	2.8	1.8	63.8	1.0
Тээврийн хэрэгслийн татвар	0.0	0.2	0.0	15.8	0.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.0	0.1	0.1	52.8	0.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.6	2.3	0.7	30.6	1.6
Газрын төлбөр	0.1	0.3	0.0	18.2	0.2
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.2	0.4	0.2	53.4	0.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.7	1.8	0.5	25.9	1.3
Бараа үйлчилгээний бусад зардал	25.9	64.7	29.1	45.0	35.6
Бараа үйлчилгээний бусад зардал	20.7	57.3	25.4	44.3	31.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5.2	7.4	3.7	49.6	3.7
ХҮҮ	148.6	214.7	107.7	50.2	107.0
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	40.4	64.2	28.8	44.9	35.4
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	108.2	150.5	78.9	52.4	71.6
ТАТААС	46.8	77.5	47.0	60.6	30.6
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1.2	5.0	1.6	31.7	3.4
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	45.6	72.6	45.4	62.6	27.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398.5	463.2	406.7	87.8	56.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	2.9	5.8	2.3	39.7	3.5
Засгийн газрын дотоод шилжүүлэг	2.8	3.7	2.0	53.1	1.7
Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.1	2.1	0.3	16.4	1.8
Бусад урсгал шилжүүлэг	395.6	457.4	404.4	88.4	53.0
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	260.6	285.2	280.0	98.2	5.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	92.9	123.5	102.8	83.3	20.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.6	1.4	0.7	49.9	0.7
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17.8	34.2	11.9	34.9	22.3
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	70.8	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9.1	7.6	5.4	70.6	2.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13.8	3.1	2.8	89.2	0.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.7	2.4	0.8	33.2	1.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	123.7	301.2	112.2	37.2	189.0
Барилга байгууламж	101.2	209.8	95.6	45.5	114.2
Их засвар	0.8	11.9	2.8	23.1	9.2
Тоног төхөөрөмж	1.7	31.5	4.2	13.2	27.3
Бусад хөрөнгө	2.0	44.9	6.7	15.0	38.2
Стратегийн нөөц хөрөнгө	8.5	3.1	3.0	96.9	0.1
Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	9.7	0.0	0.0	-	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35.1	69.0	6.1	8.9	62.9
Эргэж төлөгдөх зээл	20.6	27.6	-2.9	-10.4	30.5
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	0.0	0.0	0.0	-	0.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	14.5	41.4	9.0	21.8	32.3


Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 89.4 хувь болж, өнгөрсөн оноос 2.9 пунктээр өссөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 89.4 хувь буюу 998.6 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 43.8 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 10.8 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.7 хувийг татаас, 40.7 хувийг урсгал шилжүүлэг эзэлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 17.6 тэрбум төгрөгөөр буурчээ. Үүнд: зээлийн үйлчилгээний төлбөр 40.9 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц /хувиар/



Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд улсын төсвийн 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан төсөв 400.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.

Улсын төсвийн нийт зарлагын 18.6 хувийг Сангийн сайдын багц, 20.8 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багц, 9.3 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 19.9 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 6.7 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 2.8 хувийг Батлан хамгаалахын сайдын багц, 0.1 хувийг Зам, тээврийн хөгжлийн сайд, 3.6 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц, үлдэх 8.0 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зардал эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Хүснэгт 6.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	2018 оны эхний 02 сарын гүйцэтгэл			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	867.6	684.7	182.9	78.9
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	6,936.1	5,298.2	1,637.9	76.4
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	21,478.9	10,899.0	10,579.9	50.7
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	2,720.2	1,594.2	1,126.1	58.6
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	12,735.5	9,502.8	3,232.7	74.6
САНГИЙН САЙД	294,543.6	168,131.8	126,411.8	57.1
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	36,199.4	25,164.6	11,034.8	69.5
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	113,631.7	84,543.6	29,088.1	74.4
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	241.0	197.3	43.7	81.9
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	797.6	476.3	321.3	59.7
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	8,382.9	6,956.0	1,426.9	83.0
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	4,680.4	4,253.0	427.4	90.9
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	364.9	345.4	19.5	94.6
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,936.8	1,629.1	307.6	84.1
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	1,412.2	909.6	502.5	64.4
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	497.7	363.9	133.8	73.1
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	92.8	89.6	3.2	96.5
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	80.2	61.9	18.4	77.1
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	19,201.2	14,280.3	4,920.9	74.4
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	150.5	129.7	20.8	86.2
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	194.7	162.6	32.1	83.5

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	5,393.2	2,099.7	3,293.5	38.9
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	13,823.7	6,839.2	6,984.5	49.5
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	72,925.1	60,304.4	12,620.6	82.7
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	8,781.3	3,855.7	4,925.6	43.9
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	245,102.4	188,600.1	56,502.3	76.9
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	148,015.2	94,192.0	53,823.2	63.6
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	2,937.4	861.5	2,075.9	29.3
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	44,738.7	32,841.5	11,897.3	73.4
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	7,269.5	636.6	6,632.9	8.8
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	229,730.5	179,815.1	49,915.4	78.3
НИЙТ ЗАРДАЛ	1,305,862.7	905,719.3	400,143.5	69.4

Эх сурвалж: Сангийн яам

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 10.4 тэрбум төгрөг зарцуулж, 33.7 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

График 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөгөөр/



Улсын төсвийн хөрөнгөөр 2018 оны эхний 02 сард хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 30.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс 10.4 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 20.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Хүснэгт 7.

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВТ ӨРТӨГ	2018 оны эхний 02 сарын гүйцэтгэл				
		Төсөвт өртөг	Төлөв.	Гүйцэт.	Зөрүү	Хувь
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	770.7	770.7	0.0	0.0	0.0	
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1,913.3	1,913.3	0.0	0.0	0.0	
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	5,685.3	3,762.8	0.0	0.0	0.0	
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	12,695.2	6,006.4	184.3	0.0	184.3	-
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	23,920.9	11,881.8	45.0	0.0	45.0	-
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	12,789.5	10,389.5	0.0	0.0	0.0	
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	1,800.0	1,800.0	0.0	0.0	0.0	
САНГИЙН САЙД	78,098.1	32,810.0	1,560.0	0.0	1,560.0	-
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	59,590.9	37,390.0	363.6	0.0	363.6	-
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	36,723.3	17,340.0	450.0	450.0	0.0	100.0
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	19,417.4	3,599.5	0.0	0.0	0.0	
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	430,501.9	80,338.4	5,787.3	1,504.1	4,283.2	26.0
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	739,860.0	262,817.6	4,438.1	2,249.6	2,188.4	50.7
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	342,951.3	80,796.9	12,707.5	4,798.8	7,908.7	37.8
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	3,980.0	3,980.0	143.1	0.0	143.1	-
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	41,521.3	27,818.5	0.0	0.0	0.0	
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	151,489.7	37,661.9	2,003.8	0.0	2,003.8	-
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	193,319.5	60,754.8	3,081.9	1,372.7	1,709.2	44.5
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	195.6	195.6	0.0	0.0	0.0	
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	340.0	340.0	0.0	0.0	0.0	
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	1,562.0	452.0	0.0	0.0	0.0	
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	500.0	500.0	0.0	0.0	0.0	
НИЙТ	2,159,625.8	683,319.8	30,764.5	10,375.2	20,389.3	33.7

Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид эхний 02 сард 1.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс эхний 02 сарын байдлаар 0.6 тэрбум төгрөг зарцуулж 32.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барих-шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл арга, хэмжээ, барилга байгууламжийн 2018 оны эхний 02 сарын санхүүжилтийн гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчдаар/


Хүснэгт 8.

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР, ХУЧИН ЧАДАЛ, БАЙРШИЛ	ТӨСӨВТ ӨРТӨГ	2018 оны эхний 02 сар		ЗӨРҮҮ	ХУВЬ
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	82,884.4	1,844.2	589.3	1,254.9	32.0
Үндэсний хөгжлийн газар	82,884.4	1,844.2	589.3	1,254.9	32.0
<i>Концессын төслийн эргэн төлөлт</i>	<i>82,884.4</i>	<i>1,844.2</i>	<i>589.3</i>	<i>1,254.9</i>	<i>32.0</i>
I.Хөрөнгө оруулалт	82,884.4	1,844.2	589.3	1,254.9	32.0
Шилжих	82,884.4	1,844.2	589.3	1,254.9	32.0
Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам	32,324.4	0.0		0.0	
Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам	48,715.8	0.0		0.0	
Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил	584.9	584.9		584.9	
Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	670.0	670.0		670.0	
Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор/	589.3	589.3	589.3	0.0	100.0
НИЙТ ДҮН	82,884.4	1,844.2	589.3	1,254.9	32.0

Эх сурвалж: Сангийн яам

5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сан

График 7. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөгөөр/




2018 оны эхний 02 сард эрүүл мэндийн даатгалын санд 44.1 тэрбум, нийгмийн даатгалын санд 301.8 тэрбум, нийт 345.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 41.4 тэрбум төгрөг буюу 13.6 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого: 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 301.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 7.0 хувь буюу 19.6 тэрбум төгрөгөөр давж биелэн орлогын гүйцэтгэл 107.0 хувьтай гарчээ. 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр ажил олгогч, даатгуулагчаас нийгмийн даатгалын санд нийт 199.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, мөн тус санд улсын төсвөөс 102.2 тэрбум төгрөгийн татаас олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг сангийн төрлөөр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын санд 150.9 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 17.1 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 25.8 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 5.8 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого: Эрүүл мэндийн даатгалын санд 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр нийт 44.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 22.0 хувь буюу 12.4 тэрбум төгрөгөөр дутуу биелэн орлогын гүйцэтгэл 78.0 хувьтай гарчээ.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн зарлага:


График 8. Эрүүл мэнд нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөгөөр/



2018 оны эхний 02 сард эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 40.5 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 282.7 тэрбум, нийт 323.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 23.7 тэрбум төгрөг буюу 7.9 хувиар өссөн байна. Үүнд: тэтгэврийн даатгалын сангийн зарлага 23.5 тэрбум төгрөг буюу 10.2 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 2.4 тэрбум төгрөг буюу 17.4 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 0.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага: 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр тус сангийн нийт зарлага 282.7 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 5.8 тэрбум төгрөг буюу 2.0 хувиар дутуу зарцуулагдсан байна.

График 9. Нийгмийн даатгалын сангийн нийт зардалын бүтэц



2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэрт болон бусад зардалд нийт 254.5 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсэн ба амаржсаны, оршуулгын тэтгэмж болон бусад зардалд 16.2 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэр, сувиллын болон бусад зардалд 7.7 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж болон бусад зардалд 5.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага: 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 57.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 40.5 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн зарлагын гүйцэтгэл 70.8 хувьтай гарчээ.

6. Орон нутгийн төсөв

2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 161.3 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.


2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 416.9 тэрбум төгрөгт хүрсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 1.4 хувь буюу 6.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрч, нийт зарлага 290.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 35.7 хувиар буюу 161.3 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 14.1 хувиар буюу 51.4 тэрбум төгрөгөөр, нийт зарлага 0.1 хувь буюу 0.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 42.2 хувийг орон нутгийн төсвийн орлого, 9.4 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 46.3 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 2.1 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг эзэлж байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 39.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

График 10. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг болон аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Хүснэгт 9.

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	3,047.1	3,047.1	100	6,329.6	6,329.6	100	329.0	329.0	100
Баян-Өлгий	2,910.5	2,910.5	100	7,428.7	7,428.7	100	465.3	465.3	100
Баянхонгор	5,431.7	5,431.7	100	7,852.8	7,852.8	100	355.7	355.7	100
Булган	0.0	0.0	-	5,331.3	5,331.3	100	209.0	209.0	100
Говьсүмбэр	0.0	0.0	-	6,592.6	6,592.6	100	318.6	318.6	100
Говь-Алтай	2,129.8	2,129.8	100	1,435.9	1,435.9	100	53.5	53.5	100
Дархан-Уул	0.0	0.0	-	5,497.7	5,497.7	100	267.2	267.2	100
Дорноговь	0.0	0.0	-	5,201.3	5,201.3	100	297.4	297.4	100
Дорнод	1,300.0	1,300.0	100	5,112.9	5,112.9	100	338.4	338.4	100
Дундговь	1,332.6	1,332.6	100	4,306.2	4,306.2	100	186.7	186.7	100
Завхан	2,399.5	2,399.5	100	6,700.8	6,700.8	100	323.4	323.4	100
Орхон	0.0	0.0	-	5,767.5	5,767.5	100	317.5	317.5	100
Өвөрхангай	3,970.2	3,970.2	100	7,293.3	7,293.3	100	399.9	399.9	100
Өмнөговь	0.0	0.0	-	5,393.9	5,393.9	100	304.7	304.7	100
Сүхбаатар	1,416.3	1,416.3	100	4,962.1	4,962.1	100	246.5	246.5	100
Сэлэнгэ	1,350.0	1,350.0	100	7,816.6	7,816.6	100	351.5	351.5	100
Төв	1,996.0	1,996.0	100	7,605.7	7,605.7	100	291.7	291.7	100

Увс	2,800.0	2,800.0	100	7,509.8	7,509.8	100	396.2	396.2	100
Улаанбаатар	0.0	0.0	-	63,320.3	63,320.3	100	1,962.0	1,962.0	100
Ховд	2,220.0	2,220.0	100	6,629.3	6,629.3	100	413.6	413.6	100
Хөвсгөл	3,681.4	3,681.4	100	8,819.6	8,819.6	100	502.8	502.8	100
Хэнтий	3,000.0	3,000.0	100	6,305.9	6,305.9	100	284.0	284.0	100
ДҮН	38,985.2	38,985.2	100	193,213.9	193,213.9	100.00	8,614.8	8,614.8	100

Эх сурвалж: Сангийн Яам

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 193.2 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгосон байна.

2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 8.6 тэрбум төгрөгийг шилжүүлж, аймаг орон нутагт хуваарилсан нь төлөвлөсөн хэмжээнд 100.0 хувь хүрч биелжээ.

Орон нутгийн орлогыг зарим аймгуудаар харуулбал, Булган аймаг 803.7 сая, Говьсүмбэр аймаг 45.3 сая, Дархан-Уул аймаг 278.5 сая, Завхан аймаг 120.1 сая, Өвөрхангай аймаг 190.6 сая, Сэлэнгэ аймаг 374.2 сая, Төв аймаг 512.6 сая, Хөвсгөл аймаг 213.3 сая болон Хэнтий аймаг 973.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд дараах дүгнэлт өгөхөөр байна. Үүнд:

Төсвийн орлогын хувьд: 2018 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,190.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 104.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн, мөн өмнөх оны мөн үеэс 226.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл 2018 оны 01 дүгээр сард 4.2 хувь, эхний 02 сард 9.6 хувиар тус тус давж биелсэн байна.
- Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2018 оны эхний 2 сард 23.5 хувь буюу 226.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө биелэхэд татварын орлогын өсөлт голлон нөлөөлсөн байна. Үүнд: Татварын орлого 2018 оны эхний 01 сард 6.9 хувь буюу 30.2 тэрбум төгрөгөөр, эхний 02 сарын байдлаар 14.5 хувь буюу 133.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ. Татварын орлогын хувьд хөрөнгийн албан татвар, онцгой албан татвар болон тусгай зориулалтын орлогын татвараас бусад бүх төрлийн татварууд давж биелсэн байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2018 оны эхний 01 сард 87.8 хувь, эхний 02 сард 81.5 хувийн биелэлттэй гарч, тус татварын орлого дутуу биелсэн бөгөөд үүнд төсөвт байгууллагын өөрийн орлого болон гадаад зээл, тусламжийн орлого дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2018 оны эхний 01 сарын байдлаар 486.9 тэрбум төгрөгөөр, мөн эхний 02 сарын байдлаар 620.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 01 дүгээр сард 53.9 хувиар, эхний 2 дугаар сард 35.7 хувиар тус тус дутуу зарцуулагдсан байна.

- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ 2018 оны эхний 01 сард 19.8 хувийн гүйцэтгэлтэй гарч, 5.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон бол эхний 02 сарын байдлаар 33.7 хувийн гүйцэтгэлтэй гарч 10.4 тэрбум төгрөгийн санхүүжилт гарчээ.
- Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үеэс 40.9 тэрбум төгрөгөөр буюу 27.5 хувиар буурч, төлөвлөснөөс 107.0 тэрбум төгрөгөөр бага зарцуулагдсан байна. Энэ нь төсвийн нийт зардал буурахад нөлөөлсөн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА